

дэмждэг. Харин ньюд урлагийн бүтээлийг харснаараа хүн гоо зүйн таашаал, урлагийн бүтээлийг ойлгох боломжтой болдог.

Урлагийн бүтээлийг олон нийтийн орон зайд байршуулахдаа цензуртэй хандаж, түүнийг нийтийн эзэмшлийн газарт байрлуулахыг хориглох тохиолдлууд зөвхөн монголд бус дэлхийн улс орнуудад одоо ч гарсаар байна. Ньюд урлагийн бүтээлийг олон нийтийн орчинд дэлгэн харуулах нь ямар нэг байдлаар гажуу буруу зүйлд уруу татсан зүйл биш учир үүнд цензур тавих нь учир дутагдалтай юм. Тийм ч учир ньюд урлагийн бүтээлийг харагдах байдлаар дүгнэх биш түүний илэрхийлэх гэсэн санаа, зорилгыг нь илрүүлэх нь ньюд урлагийн бүтээл болоод порнографын хүрээ хязгаарыг тодруулан ялган салгах боломжтой болно

Ном зүй

Монгол хэл дээрх ном:

Вольф, Роберт Пол. (1960 [2021]). *Философийн тухай*. Улаанбаатар, Монгол: Мөнхийн үсэг Жэйнс, К., нар. (2013). *АУГАА уран зургууд*. Улаанбаатар, Монгол: Непко

Англи хэл дээрх ном:

Cresswell, J. (2021). *Oxford Dictionary of Word Origins (Oxford Quick Reference)*. Oxford University Press

Hoffman, B. (2015). *Naked: A Cultural History of American Nudism*. NYU Press.

Kissick, J. (1995). *Art context and criticism*. Synergy, Singapore: McGraw-Hill

Plato. (1943). *Plato's The Republic*. New York :Books, Inc.

Англи хэл дээрх сэтгүүл:

Atkins, R. (1991). A Censorship Time Line. *Art Journal*, 50(3), 33–37.

Blair, L. (1996). Strategies for Dealing with Censorship. *Art Education*, 49(5), 57–61.

Devereaux, M. (1993). Protected Space: Politics, Censorship, and the Arts. *The Journal of Aesthetics and Art Criticism*, 51(2), 207–215.

Louw, D. J. (2017). Aesthetics of the Naked Human Body: From Pornography (Sexualised Lust Object) to Iconography (Aesthetics of Human Nobility and Wisdom) in an Anthropology of Physical Beauty. InTech.

Maxwell, E. C. (1911). The Value of the Nude in Art. *Fine Arts Journal*, 24(1), 2–11.

Nanay, Bence, '9 Anti-Pornography: André Kertész's Distortions', in Hans Maes, and Jerrold Levinson (eds), *Art and Pornography: Philosophical Essays* (Oxford, 2012; online edn, Oxford Academic, 24 Jan. 2013)

Henley, D. (1997). Art of Disturbation: Provocation and Censorship in Art Education. *Art Education*, 50(4), 39–45.

РЭНДАЛЛ КОЛЛИНЗИЙН ЖУУХИЗМЫН СОЦИОЛОГИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ

Су-мин Ху, Голуэйн Үндэстний Их Сургууль, Ирланд Улс.

Орчуулсан: А.Хишигтөгс, социологич, Ирланд Улс.

Abstract: This article reflects on Collins' classic work, *The Credential Society* (Collins, 1979), situating his critique of educational credentialism within broader 'conflict sociology' (Collins, 1975). The discussion reappraises Collins' work in the context of the 'new credentialism' and the race, gender and class concerns raised in current debates on higher education. The article characterizes contemporary higher education as being trapped in a Procrustean dynamic: techno-utopianism with job displacement and expansionism with declining public support. Collins attempts to escape the legacy of structural-functionalism through conflict sociology or predictions of systemic crisis. This is contrasted with his contemporary, Herbert Gintis' eclectic attempt to construct a transdisciplinary social science. The

key problem of marketized inequality is linked to the sociology of absences in conflict sociology, and it is argued that inequalities of class, race, gender and coloniality in higher education and credentialism can no longer be ignored.

Keywords: credentialism, Randall Collins, higher education, jobs, conflict sociology

Орчуулагчийн үг

Креденциализм гэсэн боловсролын социологийн орчин үеийн чухал ухагдахууныг жуухизм гэж буулган нутагшуулахыг зорив. Жуух гэдгийг Монгол хэлний Журамласан толь-д: *дээд газраас олгох сайшаалын бичиг; итгэмжлэл, үнэмлэх бичиг* гэж тодорхойлжээ. Жуух гэдэгт боловсрол эзэмшсэнийг нотлох диплом, гэрчилгээ, үнэмлэх, батламж, өргөмжлөл, мөн голдуу бакалавр, магистр, докторын зэргийг ойлгоно. Өөрөөр хэлбэл, жуухизм нь боловсролын мөн чанарыг ойлгохгүйгээр ажилд орохын тулд их дээд сургуульд сурах өнөөгийн хуйларч буй зан хандал, үүнийг бий болгож, хадгалж, хамгаалж байгаа тогтолцоог илэрхийлсэн ухагдахуун.¹⁰

Жич: Жуух гэсэн үгийг монгол хэлэнд хэт өрөөсгөл хэрэглээ болсон “жуух бичиг” гэх төрөөс олгодог шагналтай холих шаардлагагүй.

Ангийн зөрчил нь төсөөлж байснаас харин ч илүү өргөн хүрээтэй, гэхдээ харин ч илүү бага түүхэн хувьсгалт шинжтэй байх бололтой (CS 71).

1. Оршил

Энэ өгүүлэлд Рэндалл Коллинзийн¹¹ *Жуухын Нийгэм*¹² (Collins, 1979) хэмээх сонгодог бүтээлийг хөндсөнболно. Креденциализм буюу жуухизмын талаарх түүний шүүмжлэл нь "зөрчилдөөний социологи"-ийг (Collins, 1975) хөгжүүлсэн. Уг социологийн онолоороо гэрээр Веберийн статус ба мэргэжлийг авч үзсэн түүхэн-тайлбарлах социологийг (Weber, 1978 [1922]), Сэмүэл Боулз болон Херберт Гинтис нарын аж үйлдвэржсэн капитализм дахь сургуулилалтын шүүмжлэлтэй (Bowles & Gintis, 1976) холбосон. Жуухизм бол дээд боловсрол, меритократ¹³, хөдөлмөр эрхлэлт, тэр ч байтугай социологийн хөдөлмөрийн зах зээлийн талаарх шүүмжлэлт маргаанд хамаарах орчин үеийн өргөн цар хүрээтэй, мөнх ногоон сэдэв (Lemann, 1999; Headsworth & Freese, 2016; Cottom, 2017; Tholen, 2017) юм.

Коллинз Хүмүүн капиталын функционалист, технократ онолоор академик жуух бол үйл ажиллагааны нугас, цаашид үргэлжлэн давамгайл байдал олгодог зүйл хэмээн шүүмжилдэг. (Becker, 1964). Зөрчилдөөний хандлага нь, боловсрол нь ур чадвар, мэдлэгтэй ямар холбоотой вэ, жуух гэдэг нь юу гэсэн үг вэ, дээд боловсрол ба хөдөлмөрийн зах зээлийн хооронд бодитой ямар хамаарал байдаг вэ, "хөдөлмөрийн зах зээл" гэж юу вэ гэсэн асуултуудыг тавьдаг. Даяаршил эрчимжиж байгаатай холбоотойгоор өөрчлөгдөж буй хөдөлмөрийн зах зээлтэй дээд боловсролын харилцах харилцаа өнөөдөр 1970-аад оныхтой харьцуулахад илүү хурцадмал болсоор. Коллинзийн жуухизмын шүүмжлэл нь боловсролын социологи, ажил ба байгууллагын социологи, мэдлэгийн социологид

¹⁰ Эхийг Англи хэл дээрх хувилбараар харна уу:

https://www.researchgate.net/publication/335763023_Reflections_on_Randall_Collins%27s_sociology_of_credentia%27alism

¹¹ Орч. А.Х: Randall Collins бол Америкийн социологич, зөрчилдөөний онолч. Тэрээр Пенсильванийн Их Сургуульд профессороор ажиллаж, 2010-2011 онд Америкийн Социологийн Холбооны (ASA-American Sociological Association) ерөнхийлөгчөөр ажиллаж байсан.

¹² The Credential Society

¹³ Орч. А.Х: Хамгийн авьяас чадвартай хүмүүс удирдах албан тушаалыг эзэлдэг тогтолцоо.

Commented [2]: Удиртгал гэвэл ямрав?

Commented [BT3]: Өгүүлбэрийн санаа нь Коллинзийн з/социологийг хөгжүүлсэн үзэл санааны нэг хэсэг нь энэ шүүмж гэж байх шиг байна. Үнэтэ хувь нэмэр гэсэн зүйл байхгүй байна.

Commented [BT4]: Strand of sociological theorizing (социологийн онолчлолын салбар/салаа)

голлох байр суурьтай хэвээр байна. Үүнийг дэлгэрүүлэхээр, Колумбийн Их Сургуулийн хэвлэлд энэ жил хэвлэгдсэн Тресси МакМиллан Коттомын өмнөх үгтэй шинэ хэвлэлийг энд тусгав.

Социологич Коттом өөрийн *Доод Бо* (2017)¹⁴ хэмээх номондоо, жуухизмыг улс төрийн эдийн засгийн өнцгөөр шүүмжилж, төрийн бюрократ жуухизм нь шинэ эдийн засагт хувийн шинжтэй, ашгийн төлөөх зах зээлийн бюрократ жуухизмаар солигдсон хэмээжээ. Эмэгтэйчүүд хийгээд цагаан арьст бус иргэдийн төлөөлөл болох хоёр сая орчим америкчууд нийт хүн амд эзлэх жинтэйгээ пропорционал бусаар ашгийн төлөөх "Доод Бо"-д түлхүү элсдэгийн шалтгаан нь тэд хэдийгээр нэр хүнд муутай, хагас цагийн болон богино хугацааны боловч боловсролын зэргийг харьцангуй хямд үнээр олгодогт байгаа юм. Коттомын тооцоолсноор, 2000-аад онд Гоо Сайханы Коллежид есөн сарын гэрчилгээ авахад 15'000 доллар зарцуулдаг байсан. 2014 онд ... Атлантагийн дагуул хотын нэгэн ижил гоо сайхны коллеж 21'436 долларын үнэтэй байв (Cottom, 2017, 2 p. 162). Санхүүгийн байдал нь ядуу оюутнууд улам л өр тавьж, өр төлбөрөө төлж чадахгүй болох магадлалыг нэмэгдүүлснээр тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлж, өргөжүүлэх гол хөдөлгөгч хүч болдог байна. "Доод Бо"-ийн оюутнуудад¹⁵, хэрвээ курсээ амжилттай дүүргэж, төгсөж чадвал ур чадвараасаа хамаараан мэргэшлийнхээ дагуу хөдөлмөр эрхлэх боломжтой хэмээн дөвийлгөн амладаг. "Шинэ жуухизм нь өндөр цалинтай, эрэлт ихтэй ажлыг амлах боловч статистикийн ялгаварлалд өртүүлдэг" (Cottom, 2017, p. 176). Шинэ жуухизм нь хэдийгээр амжилт амлах боловч үнэндээ нийгмийн хөдлөнг чанарын¹⁶ байтугай тогтвортой амьдралын баталгаа болж чадахгүйгээс ядуувтар, арьс өнгөөр ялгаварлагдагсад болон эмэгтэй голдуу оюутнууд "харгис өдрөг үзэл"-ийн (Berlant, 2011) төлөө өндөр үнэ төлөөд дуусдаг байна.

2. Жуухын нийгэм

Коллинз жуухизмыг эрх мэдлийн төлөөх тэмцлийн болон зөрчлийн динамикийн ерөнхий онолын үүднээс тайлбарладаг. Түүний "илүү дутуу зүйлгүй шууд гол ажилдаа орох шинжлэх ухааны онол" (Seidman 2017, 87) нь судалгаа, онол хоёрыг шууд "шинжлэх ухаан"-чаар холбодог гэж мэтгэдэг. . Үүний ойлгуулах, тайлбарлах оролдлого нь шалтгааныг эрх болон эмпирик фокустайгаар нийгмийн зан үйлийн талаарх ерөнхий тайлбарыг боловсруулах зорилготой. Үүний үндсэн таамаглал нь нийгмийн амьдрал бол тэмцэл, зөрчлийн талбар бөгөөд ингэхдээ Веберийн үзсэнчлэн эдийн засгийн анги, соёлын статус, нийгэм-улс төрийн хамаарал зэргийн хагаралыг өргөнөөр хамаарах олон төрлийн тэмцлийг агуулна. Хувь хүмүүс болон бүлгүүд боловсрол зэрэг боломжит бүх нөөцийг ашиглан хүчний давуу талыг бий болгох, хадгалах, хамгаалахын тулд ажилладаг. Боловсролын жуухууд бол давуу эрх буюу эрх ямба олж авах, хуримтлуулах хэрэгсэл бөгөөд меритократ хөдөлмөрийн зах зээлийг бүрэн биш юмаа гэхэд багагүй асуудалд оруулдаг.

Жинхэнэ мэдлэг эсхүл оюуны капиталас нийгмийн капитал нь давсан нөхцөлд мэдлэг, боловсрол, соёлын хүчний төлөөх олон тооны тэмцэл явагддаг. 1970-аад он нь аж үйлдвэржилтээс ангижирч, даяаршсан шинэ нийгмийн бодит байдлыг авчирсан бөгөөд бүтээмж дэх хөдөлмөрийн хувь хэмжээ ч буурсан. Ажил мэргэжлийн давхраажилт нь "улс төрийн хөдөлмөр"-өөр удирдуулах болов, өөрөөр хэлбэл, нэлэнхийдээ төрийн дэмжлэгтэй "хөлс хүч шаардахгүй өндөр цалинтай албан тушаал"¹⁷ бүхий салбар"-ыг түшиж налах болов. Хувь хүмүүс болон бүлгүүд соёлын мөнгөн

¹⁴ Орч. А.Х: Социологич Коттом *Lower Ed* номоороо дээд боловсрол эзэмших хүсэлтэй ч боломж нь хомс байгаа оюутнуудыг мөлждөг ашгийн төлөө коллежууд олширч байгааг шүүмжилсэн. Higher Education буюу дээд боловсрол хэрхэн Lower Ed буюу доод боловсрол болж байгааг илэрхийлэхийн сацуу Ed гэснээр Education буюу боловсролыг үгүй хийн хугаслаж байгааг егөөдөн "боловсрол" гэхийн оронд "бо" гэсэн болов уу.

¹⁵ Орч. А.Х: Доод Бо-ийн оюутнууд гэдгээр чанартай дээд боловсрол эзэмших туйлын хүсэл тэмүүлэлтэй ч төлбөрийн чадамжгүйгээс болоод нэр хүндгүй, ашгийн төлөөх, чанартай боловсрол олгож чадаггүй дээд сургуульд сурч буй оюутнуудыг ойлгоно.

¹⁶ Орч. А.Х: Social mobility буюу нийгмийн хөдлөнг чанар гэдгээр хүн ямар төрсөн гэдгээс үл хамааран өөрийн олж авсан статусаар өөрийн амьдрал, байр суурь, нийгмийн анги, давхаргаа солих боломжийг ойлгоно. Тухайлбал, хүн ядуу айлд төрсөн ч сурч боловсорсноор мэргэжилтэн эсхүл сэхээтэн болж, нийгмийн дундаж эсхүл дээд давхаргад орох нь нийгмийн хөдлөнг чанарын илэрхийлэл.

¹⁷ Sinecure

тэмдэгтээрээ, нэрлэбэл боловсролын жуухизмаараа үүдэл хийж "хөлс хүч шаардахгүй өндөр цалинтай албан тушаал"-ыг монопольчлохын тулд улс төрийн хөдөлмөрийг ашигладаг. Технологи нь хөдөлмөрийн бүтээмжийг ажлаас давах боломжийг олгодог шинэ нөхцөлийг харгалзвал энэхүү тайлбар нь Марксын суурь бүтэц ба дээд бүтцийн тухай ойлголтыг¹⁸ үндсэндээ урвуу харуулдаг. Материаллаг бус соёл нь материаллаг баазаас илүү нийгмийн бүтцийг тодорхойлдог: "соёлын солилцоо нь давхраажилтын бүх хэлбэрийг бий болгож, ажил болон материалын төлөөх ангийн тэмцлийг явуулдаг зохион байгуулалттай эмпирик арга хэрэгсэл" (Collins, 1979, хуудас 58).

Энэ анализ нь роботууд хүний хөдөлмөрийг шахан зайлуулах эсэх мөн боловсролыг дахин зохион бүтээх шаардлагатай болсон тухай маргааныг урьдчилан харуулж байна. Зөрчилдөөний онолууд шүүмжлэлт шинжтэй, тиймээс хүйтэн хөндий. Энэ утгаараа нийгмийн бүтцүүд байдаг, гэхдээ тэдгээр нь ихэвчлэн амьдрахад таагүй газар байдаг. Энэ таагүй байдал нь социологийн төсөөллийг өдөөж, тодорхой юм уу хувь хүний нөхцөл байдал болон өргөн хүрээний нийгмийн бодит байдал юм уу нийгмийн "систем" хоёрын хоорондын уялдаа холбооны тухай асуултуудыг ил гаргаж ирдэг. Буруу болсон юмсын сүүдрээс зайлсхийх боломжгүй болдог. Бүхэл бүтэн системүүд эвдэрч болох тул "систем"-ийн мөн чанарт өөрт нь эргэлзэхэд хүргэдэг. Академик ертөнцийнхний хувьд дээд боловсрол, жуухчлалын хабитус, өөрсдийн мэргэжлийнхээ үүрэг, онцлогтой холбоотой уг "систем" нь таагүй санагдахаас гарцаагүй хэрэг билээ.

Жуухын нийгэм нь гурамсан давамгайл бодлын хэв маягаар сорьж, эргэцүүлэхэд хүргэдэг. Эхнийх нь нийгмийн тэмцэл, зөрчилдөөн, шаталсан эрэмбийн талбараас ялгаатай нь ажил мэргэжлийн ангичлалын функциональ схем болох "нийгмийн давхраажилт"-тай холбоотой. Хоёр дахь нь нийгмийн хөдлөнг чанар, хөдлөнг бус чанар, ялгаатай үр дагаврыг нийгэм, улс төрийн хувьд хууль ёсны гэж зөвтгөдөг меритократ идеологийн тухай авч үзнэ. Гурав дахь нь боловсрол, мэдлэг, технологид суурилсан инноваци, бүтээмж, ажлын байр хоорондын хувьсал, харилцан хамааралтай харилцааны талаарх таамаглалтай холбоотой. Эдийн засаг, нийгэм-соёлын шатлалыг мерит зарчмаар болоод үр ашигтай гэдгээр зөвтгөдөг (Young, 1958) шиг тус гурамсан бодлыг бүтэц-үүргийн уран зөгнөл гэж үгүйсгэж болно, гэвч бодит байдал дээр тус өөр: *"Мерит зарчмаар хувь хүний мэдлэг, чадвараар томилох нь сайн хэрэг. Тодорхой төрлийн мэдлэг, чадвартай гэж дүгнэгдсэн хүмүүс бусдад орох орон зайгүй шинэ нийгмийн анги руу түлхэж дагариулахад энэ нь эсрэгээрээ муу хэрэг болдог"* (Young, 2001).

Зөрчилдөөний жуухист шүүмжлэл нь тогтолцоон дахь нийгмийг хашаасыг¹⁹ тайлбарлахдаа хүч нь эдийн засаг, материал эсхүл санхүүгийн капиталаар тодорхойлогддоггүй, харин бэлгэ тэмдэг эсхүл албан тушаал эзэмшсэний үр дүнд үүсдэг гэдэг. Боловсрол нь өндөр мэргэшсэн мэдлэг, ур чадварыг дамжуулахад үйлчилдэг гэсэн мэргэжилтнүүдийн байр суурийг няцааж, Коллинз "эмнэлгийн монополь" ба "хуульчдийн холбоо"-г эдийн засаг, нийгмийн байр суурийг бэхжүүлж, нийгмийн хашаасанд нөлөө үзүүлэх дүр эсгэлтээс үндсэндээ хамаарна гэж үздэг (Collins, 1979, р. 54). Меритократ тогтолцоо гэдэг нь өндөр албан тушаал, мөн үүн шигээ өндөр материаллаг

¹⁸ Орч. А.Х: Марксынхаар суурь бүтэц гэдэгт эдийн засаг зэрэг материаллаг хүчин зүйлс багтах бол дээд бүтэц гэдэгт боловсрол, шашин, хууль, гэр бүл, соёл гэх мэт идеологийн хүчин зүйлс багтана. Тэгэхээр, суурь бүтэц нь дээд бүтцээ тодорхойлж, дээд бүтэц нь суурь бүтцээ бэхжүүлдэг. Жишээлбэл, ихээхэн өмч хөрөнгөтэй капиталыг эзэмшигч капиталистууд ноёрхогч идеологийг тодорхойлно; боловсрол гэхэд санхүүгийн мэргэжлүүд хамгийн эрэлттэй, нэр хүндтэй болж, чөлөөт зах зээлийг зөвтгөсөн онолын хандлага их сургуульд давамгайлж, ерөнхий боловсролын сургуулийг ашгийн төлөө хувийн сургууль байж болно зэргээр системчилж өгдөг ба эдгээр нь эргээд тэр нийгмийн байдлаа бэхжүүлэхэд зүтгэдэг.

¹⁹ Орч. А.Х: Social closure буюу нийгмийн хашаас нь социологийн нэр томъёо бөгөөд дэлхийн аль ч нийгэмээс энэ үзэгдлийг олох боломжтой. Энэ ойлголт нь хомс нөөцийг зөвхөн өөрийн бүлэгтээ монопольчлохын тулд бусдыг ашиглаж чадахгүй болгох зорилгоор хил хязгаар тогтоох, онцлох шинжээ таниулах, бүл үүсгэх үйл явцыг хэлдэг. Элит хувийн сургуульд элсэх нь санхүүгийн чадавхиас хамаарах, шашны бүлгэмийн гишүүнчлэл нь нийгмийн хэлхээнээс хамаарах, хөгшчүүдийн шөнийн клуб ба залуучуудын шөнийн клуб нь наснаас хамаарах гэх мэт нийгмийн хашаасын жишээ түгээмэл. Монголын нийгэмд намын дэргэдэх ахмад, эмэгтэйчүүд, залуучуудын байгууллагын дэд ерөнхийлөгч болохын тулд гишүүнчлэлийн татвар төлж элсэх, мөн ажилд орохын тулд гурван үеийн намтраа танилцуулах нь нийгмийн гарвал, ар гэрийн байдлаас хамаарч байгаа тул нийгмийн хашаасын тод жишээ болно.

Commented [BT5]: Жуухчлал жуухизм энэ тэрийг нь жигдэлмээр ч юм шиг

урамшууллыг хуваарилдаг "хамгийн сайн нийгэм"-ийн ердөө нүд хуурсан цонхны чимэглэл гэлтэй, ингэхдээ хичээл зүтгэл эсхүл ур чадвар ч шаардлагагүй. Дундаж зууны үед хөлс хүч шаардахгүй өндөр цалинтай албан тушаалыг папуудаас эсхүл хаадаас авдаг байсан. Орчин үеийн нийгэмд хөлс хүч шаардахгүй өндөр цалинтай албан тушаалыг төрийн томоохон нэгжүүд, хувийн томоохон корпорацууд, мөн байгууллагын тоглоомын "дүрэм"-ийг тодорхойлох, эвсэл байгуулах, нийгмийн нийцлийг²⁰ бий болгох зорилгоор ажилладаг корпорацийн хөтөлбөрүүдийн хөгжиж буй дэд салбарууд хуваарилдаг.

Жил бүр би бакалаврын түвшний оюутнуудын ихээхэн хэсгийг социологийн чиглэлээр суралцуулж, тэднийг функционалист онолын эсрэг зөрчилдөөний онолоор меритократизм болон нийгмийн давхраажилтыг авч үзэхийг хүсдэг. Дээд боловсролын талаарх маргаанд социологичоор хандаж байхад оюутнуудын энэ даалгаврын үр дүн надад нэгэн нууцыг ойлгоход хүргэсэн билээ. Яагаад ер нь тэд социологичоор суралцахаар "сонгосон" юм бол? Бидний олгож буй дээд боловсролын эцсийн зорилго юу юм бэ? Социологийн багш бидний олгож буй боловсрол нь ажилд ороход л "хөтөлдөг" эсхүл өөр ямар нэгэн зорилгод хэрэгсэл болгодог гэдгийг бид хүлээн зөвшөөрч байгаа мэт аашилдаг. Гэсэн хэдий ч бидний боловсролын зорилго нь өдөр тутмын амьдралд, ялангуяа дээд боловсролын социологи, хөдөлмөрийн социологи, мэргэжлийн социологи, мэдлэгийн социологийг судалж байгаа хүмүүсийн хувьд тодорхой биш, зөрчилтэй хэвээр байна. Дээд боловсролд 1970-аад оноос хойш эргэлдэж эхэлсэн, 1990-ээд оноос хойш бүр өргөжсөн шинэчлэлийн хуй салхи, шүүмжлэлийн ширүүн урсгалыг үл харгалзан боловсрол, технократ, меритократ гэдгээр товчхондоо хүмүүн капиталын онол нь одоогийн статус квог шаргуугаар хэвээр хадгалж байна. Меритократ нь либерал-неолиберал нийгмүүдэд дутуу хагас байх, юу ч хийхгүй байх идеологийг өгсөөр байдаг. Засгийн газрын дэмжлэг буурах тусам боловсрол, тэр дундаа дээд боловсрол өргөжин тэлж байна. Эцсийн эцэст, нийтийг хамарсан жуухчлал нь "систем" биднийг хааш нь авч яваад байгаад эргэлзэхэд хүргэдэг.

Боловсрол өргөжсөнөөр инновац хийгээд бүтээмж бий болдог гэсэн функционал хандлагын зөвтгөлтэй Коллинз санал нийлдэггүй. Илүү боловсролтой (эсхүл ядаж илүү мэргэшсэн) нийгмүүд боловсрол багатай (эсхүл мэргэшил багатай) нийгмээс илүү их инновацлаг, бүтээмжтэй байх албагүй гэж тэрээр үзсэн. Албан боловсролоор дамжуулж буй мэдлэг нь мартагдах эсхүл "ажлын байран дээр гарсны дараа л мэдсэн" мэдлэгээр солигдох магад. Сургуульд суралцах нь тодорхой техникийн болон танин мэдэхүйн ур чадвар биш, харин ноёрхогч (дунд анги, цагаан арьст, Англо-Протестант) соёлын ёс журмын талаарх ойлголтыг нөхөн үйлдвэрлэх ажилтай ажилтай хамт үлдэж хоцорсон. Соёлыг бас статус бүлгийг²¹ нөхөн үйлдвэрлэх бас хашаасыг хадгалах гэсэн зорилготой гэсэн үг. 20-р зууны дунд үе гэхэд боловсролын зэрэг болон дипломоор жуухчлах нь хэдийн давуу эрхтэй байгаа статус бүлгүүдийн байр суурийг хадгалах гэсэн шударга биш, зардал ихтэй механизм болжээ. Статус бүлгүүд нь шинээр элсэхээр ирж буй гишүүдийг шалгаруулах, албан тушаалд томилох замаар үе дамжсан соёлын шаталсан дэг журмыг хадгалахыг хүссэн шашны урсгалуудаас үүссэн түүхтэй. Элитийн хүрээ өргөжиж, өөрчлөгдөхийн хэрээр мэргэжлийн болон бизнесийн салбарууд урд гарч ирсэн. Статусын бүлэг бүр соёлын мөнгөн тэмдэгтийг²² төрөлжсөн хэлбэр бүхий "эх үүсвэр" болгох, бүлгүүдийг нь нөхөн үйлдвэрлэх арга зам болгон боловсролыг хөгжүүлэх, өргөжүүлэх гэсэн өөрийн сонирхлыг хадгалсаар ирсэн бөгөөд харин зардлаа горилогчид өөрсдөө (эсхүл тэдний гэр бүл) хариуцдаг байв.

Боловсрол нэг хэсгийнхний л эрх байхаа больж хүн бүрийн эрх болж нийтийн болох тусам зардал буурах биш харин ч өсөхөд хүрсэн. Хэдийгээр янз бүрийн "курсууд" олширч байсан ч нийтийг хамарсан боловсролын тогтолцоо нь улам л бюрократжиж, боловсролын хэт үйлдвэрлэлд

²⁰ Social conformity

²¹ Орч. А.Х: Вебер статус бүлэг, статус анги, статус давхарга хэмээх давхраажилтын гурван бүрдэл онолыг боловруулсан. Статус бүлэг нэр төр, алдар хүнд, үндэс угсаа, арьс өнгө, шашин гэх мэт эдийн засгийн бус шинж чанартай гэдгээрээ ялгардаг.

²² Орч. А.Х: Мөнгөн тэмдэгт солицооны үүрэгтэйн адил жуухизм буюу диплом эсхүл боловсролын зэргийг ажилд орох, мөнгө олох солицооны хэрэгсэл болгож байгааг соёлын мөнгөн тэмдэгт гэсэн ойлголтоор илэрхийлсэн болов уу.

хүргэсэн. Боловсролын үйлдвэрлэгчид аль болох горилогч оюутнуудыг олшруулахыг хүсдэг, яагаад гэвэл горилогчид ирээдүйд ашиглагдах нөөц бололцоо болдог. Гэсэн хэдий ч дэндүү олон шинээр элсэхээр ирж буй хүмүүс нь статус бүлгийн хашаас үүсгэх зорилгод хөндөлсөж байгаа. Боловсролын мөн чанар нь цаг хугацааны явцад утга учиргүй болж байгаа хандлага нь Веберийн өгөөдсөн дараах замналын тусгал гэлтэй: утгаа бүлгийн соёлыг хадгалах зорилготой систем нь өөрийгөө зогсонги байдал, ялзрал, бууралтад хүргэдэг.

Арван жилийн сургууль, их дээд сургуулийг боловсролоор дамжуулан нийгмийн шалгарлын²³ меритократ даалгаварт зориулан барьж, чадавхжуулсан нийгмийн хувьсгал эцэстээ техникийн тодорхой мэдлэгийг биш, харин нийгэм, соёлын үнэт зүйлсийн явцуу хүрээг нөхөн үйлдвэрлэх болов. Харин Коллинзийн судалсан хууль, анагаах, инженер гэсэн гурван мэргэжлийн инженерийн мэргэжил нь товойх ялгаатай. Ажил олгогчид бизнес, санхүүгийн салбар зэргийг л өөгшүүлэн ажлын байр зарлан инженерийн салбарыг хязгаарлаж байгаагаас үл хамааран инженерчлэл тасралтгүй өргөжин тэлж байгаа. Анагаах, хуулийн мэргэжил нь цаанаа "улс төрийн хөдөлмөр" дээр тулгуурладаг бол инженерийн мэргэжил нь рационал хөдөлмөрийн хуваарьтай нийцсэн "бодит үр дүн" бий болгодог "бүтээмжтэй хөдөлмөр"-ийн тусгал тул нээлттэй мэргэжил хэвээр аж. Коллинз ажил мэргэжлийн шалгарал нь дагалдан сургах механизмаар явагдах хэрэгтэй гэж үзээд цаасан дээрх боловсролын зэрэг, мэргэшлээс татгалзаж, жуухчлалыг халахыг зорьсон. Ингэснээр "одоо байгаа тэгш бус байдлын талыг нь" устгана гэж бодсон (Collins, 1979, p. 202). Энэ нь өнөөгийн боловсролын зарим шинэчлэгчдийн жортой нийцэж байгаа ч АНУ болон дэлхийн хэмжээнд "шинэ жуухизм"-ийн эмпирик чиг хандлага, хүмүүс системийн нэг эрэг болж найдваргүй-аз туршсан-хэт өрсөлдөөнтэй-баталгаатай биш ажлын байранд түгшиж амьдрах²⁴, санхүүгийн мөлжлөг болон өргөн дэлгэрэн, өсөж буй эдийн засгийн тэгш бус байдал нь бусад хуваарилалтын шинэчлэлгүйгээр тэгш бус байдлыг бууруулах хэтийн төлөвийг боломжгүй болгож байна.

3. Дээд боловсрол, ажил хоёрын Прокрустэч²⁵ динамикууд

Өнөөдөр дээд боловсрол нь ухралттай ахих ахилт болон дордох замаар тэлэх тэлэлт бүхий Прокрустын динамик байдалд түгжижээ. Неолиберал болон удирдлагын шинэчлэлүүд нь оршихуйн хямралыг гүнзгийрүүлсэн (Connell, 2019). Энэ нь нэг хэсэг нь үндэстний болон дэлхийн элитүүдийн өрсөлдөхүйц лигийн жагсаалтад орж, үлдсэн хэсэг нь "Доод Бо" руу шахагдсан хайр найргүй тэлж бас өсөж байгаа давхраажилтыг дараагүй.

Дээд боловсролыг өргөжүүлэхэд академик социологичид биечлэн оролцож байгаа нь тийм ч сайн хэрэг биш. Бид дээд боловсролын зорилго, хамаарал, тогтвортой байдлын талаарх тогтмол бас эвгүй асуултуудаас зайлсхийж чадахгүй. Сонгогчиддоо боловсролын эрхийг нь эдлүүлэх боломжийг бүрдүүлнэ гэж амласан ч төрийн тогтолцоог санхүүжүүлж чадахгүй байгаа засгийн газруудаас авахуулаад бүх талаас дарамт ирж байна. Жишээ нь, зуучлуулан боловсролын нэвтрүүлэг хөтөлгөчид болон ТЕД илтгэгчид анхаарлын орон зайг булаахын тулд түлхэлдэж, оюутны байгууллага, хэмжээ, олон янз байдал нь өсөн нэмэгдэж, уул овоо шиг их өртэй тулгарч, цаашид мэргэжлээрээ ажилд орж чадах эсэх нь улам бүр эргэлзээтэй болж байна. Хүмүүс

²³ Орч. А.Х: Байгалийн шалгарлаас салахын тулд хүн төрөлхтөн төрийг бий болгож, нийгэм байгуулсан ч байгалийн шалгаралтай адил нийгмийн шалгарал бий болжээ. Орчин үед нийгмийн шалгарал нь боловсролоор дамжин бий болсныг жуухизмын социологи судлах зүйлээ болгох нь гарцаагүй.

²⁴ Precarization

²⁵ Орч. А.Х: Хувь хүний ялгаа, онцгой нөхцөл байдлыг бүдүүлгээр үл тоомсорлон системийг ажиллуулахын тулд хүчлэхийг Прокрустэч хандлага гэдэг. Энэ нь Грекийн домгоос үүдэлтэй бөгөөд тэнгисийн бурхан Посейдоны хүү Прокруст хэмээх дүр нь хүмүүсийг орныхоо хэмжээнд тааруулахын тулд хөлийг сунгаж, огтолдог байжээ. Прокруст Афинд амьдардаггүй бөгөөд гэсэн дүр үзүүлэн танихгүй хүмүүст найр тавьж, дараа нь түүний орны хэмжээнд яг таарах биетэй хүн нэг ч байхгүй тул хүний биеийг орны хэмжээндээ хэрцгийгээр нийцүүлдэг байсан. Эдвард Аллан По *Хулгайлаасан захидал* (1844) гэх гэмт хэргийн тухай өгүүллэгтээ Парисын цагдаа нар сэжүүр хүчээр хэрэгт холбох, нотлох баримтыг тохируулах зэргийг илэрхийлэхдээ Прокрустын орны зүйрлэлийг ашигласан байдаг.

системийн нэг эрэг болж найдваргүй-аз туршсан-хэт өрсөлдөөнтэй-баталгаатай биш ажлын байранд түгшиж амьдрах үйл явц (прекаритизац) академик ертөнцийн хүрээнд хүртэл маш хурдацтай тархсан. Боловсролын систем нь төгсөгчдөд шинжлэх ухаан, техникийн “хатуу” мэдлэг, ур чадвар, аль эсхүл “зөөлөн” ур чадвар болох харилцаа холбоо, багаар ажиллах, бодох чадварыг эзэмшүүлэхгүй байна гэж ажил олгогчид гомдоллодог.

Ихэнх ажлын байранд тусгай ур чадвар шаардахаа больсон гэдгийг Коллинз баталж харуулсан. Автоматжилтаас гадна ажиллах хүч болон бусад нөөцийг хямд газар руу шилжүүлэх замаар ажил мэргэжлүүд хомсдож эхэлсэн. Хожуу үеийн бичвэртээ тэрээр технологийн орлолтыг капитализмын эцсийн хямралын боломжит эх үүсвэр гэж үздэг бөгөөд "Марксын болон нео-Марксист онолын тайлбарладаг явцын дагуу гэдэгтээ ч биш, харин өөрөө өөрийнхөө жамаар яваа нь энэ" (Collins, 2013, p. 37). Вебер анги, улс төр, соёлыг тайлбарлах байдлаар авч үздэг бол Марксын онол бүтцийн өөрчлөлт, хямралын талаар урт хугацааны анализыг харуулдаг. Кризис²⁶ бол гарцаагүй айсуу, яагаад гэвэл ажлын байрны технологийн орлолт нь инноваци, даяаршил, санхүүжилт, засгийн газрын зарцуулалт, жуухын инфляциас²⁷ зугтаж чадахгүй. Эдгээрийн эцэст "далдлагдсан Кейнсизм"-ын цайзад тулж очно (Collins, 2013, p. 51). Жуухын инфляци нь хэдий чинээ сурч боловсрох эрхийг хангана, төдий чинээ тэгш боломж, өндөр технологийн эдийн засгийн өсөлт, чанартай ажлын байрууд бий болно гэсэн техно-оптимист меритократ тогтолцооны үндсэн дээр өргөждөг. Боловсролыг хүртээмжтэй болгохын тулд хувьсах зардлыг төрөөс өгч, андеррайтер болгосноор төр боловсролыг Кейнсийн онолоор менеж хийнэ гэсэн үг. Энэ нь капитализмын кризисээс гарах цорын ганц боломжит арга болох боловч капиталистууд болон ажилчдаас нөөцийн томоохон дахин хуваарилалтыг шаардана (Collins, 2013, p. 56).

Борооны дараах мөөг шиг хурдан олширч байгаа биеийн бус хөдөлмөр, ялангуяа менежерист бюрократ тогтолцоо нь Дэвид Грейберийн нэрлэснээр "новшийн ажил" (нийгэмд ямар ч үр нөлөөгүй, бүтээмжийн үнэ цэн нь өчүүхэн төдий ажлууд гэсэн үг) болон "менежерийн феодализм" гэгчийг газар авахад хүргэсэн (Graeber, 2013; Graeber, 2018). Грейберийн шинэ моод болсон ойлголтууд нь үндсэндээ Коллинзийн жуухизм болон хөлс хүч шаардахгүй өндөр цалинтай албан тушаалын ойлголттой ижил: "... боловсролоор засаглах (нэрийдлээр технократыг шугамаа болгосон засаглал) гэдэг бол техникийн бодит ур чадварыг үйлдвэрлэгч гэхээсээ илүү бюрократ тогтолцооны дэмий хоосон яриа гэсэн үг" (Collins, 1979, p. 7).

"Тэргүүлэх" ажил олгогчдын цөөнхийн хувьд юу сурсан байх хэрэгтэй талаар шинэ хүлээлт бий болсон (Darling-Hammond, 2015). "Шинэ сургалт" гэдэгт хүмүүс хоорондын харилцаа, багаар ажиллах, өөрчлөлтөд дасан зохицох, асуудал шийдэх, анализ хийх, урьдчилан харах, өөрийгөө удирдах (өөрийн гүйцэтгэлийг менежментлэх гэх мэт), бүтээлч, шинийг санаачлах, шүүмжлэх чадвар зэрэг "зөөлөн" ур чадварыг агуулна. "Суралцагчид" ямар ч цаг үед шинэ зүйлсэд суралцах чадвар, мөн жич мэдлэгийн "хязгаарыг давах" чадварыг эзэмших ёстой (Wardlaw, 2006). "Шинэ сургалт"-ыг дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадварыг эрэлхийлж, тухайн улсын эрх баригчид зүтгүүлдэг. Ажилчин хувь хүмүүс туйлын өрсөлдөөнч байх шаардлагатай, үүгээр ч зогсохгүй нийгмийнхээ хэрэгцээ болох эдийн засгийн инноваци, хөгжил, шинэ нээлт, шийдэлд хувь нэмрээ оруулахад бэлэн байх шаардлагатай. Харин тэдний батгүй байдал эсхүл байхгүй боломжуудыг нь нөхөж орлохын тулд "харгис өөдрөг үзэл"-ийг бүрдүүлэх ёстой (Berlant, 2011).

2000-аад онд "Шилжилт болж буй" (Doxtator, 2017) сэдэвт цуврал бичлэгүүд сошиал медиагаар нэлээд тархсан:

2010 онд хамгийн эрэлттэй топ 10 ажлын байр 2004 онд байхгүй байсан. Одоогоор бид одоохондоо байхгүй байгаа ажлын байранд оюутнуудыг бэлтгэж байна. Асуудлаа

²⁶ Орч. А.Х: Crises гэдгийг хямрал гэх нь тийм ч тохирсон орчуулга биш, яагаад гэвэл кризис гэж шийдвэр гаргах ёстой хэцүү үеийг хэлдэг, өөрөөр хэлбэл, хямрал буюу хямрахдаа гол нь биш шийдвэр гаргах ёстой нь чухал гэсэн үг.

²⁷ Орч. А.Х: Credential inflation буюу жуухын инфляци нь үнийн инфляцитай төстэй бөгөөд олж авсан гэрчилгээ, диплом, боловсролын зэрэг нь хөдөлмөрийн зах зээл дээр үнэгүйдэхийг хэлдэг.

мэдэхгүй байж асуудлыг шийдэхийн тулд байхгүй байгаа технологийг ашиглахаар (ажлын байрууд) зүтгэж байна гэсэн үг (Shift Happens 2007).

Энэхүү "шилжилт"-ийг "Шинэ сургалт"-ыг өмөөрөгчид технологиор орлуулах шийдэл гэж уриалсан. Техно-детерминистууд технологиор бий болсон мэдлэг нь одоо байгаа бүх төрлийн мэдлэгийг хоцрогдож хуучрах болно (эсхүл аль хэдийн үеэ өнгөрөөсөн) гэж үздэг. Тус "мэдлэгийн бий болсон түвшин" буюу 1999-2003 оны хоорондох хэдхэн жилд бий болсон шинэ мэдлэг нь "урьд нь байсан бүхэл бүтэн дэлхийн түүхэнд бий болсон" бүх мэдлэгээс давах хэмжээнд хурдассан гэж тооцогддог (DarlingHammond, 2015, p. 3:20). Эдгээр аргументыг Дэлхийн эдийн засгийн форум, Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа ба Хөгжлийн Байгууллага (World Economic Forum, 2016; OECD, 2010) зэрэг байгууллагууд эрчимтэй зүтгүүлдэг. Тэд боловсролыг хоцрогдсон, моодноос гарсан загварт баригдсан гэдгээр хүчтэй шүүмжилдэг ч боловсролын тогтолцоог энэ чигээрээ тасралтгүй өргөжүүлснээр ямар мөхөлд хүрч болзошгүй болохыг урьдчилан сануулж чадахгүй хэвээр.

Ерөнхийдөө дээд боловсролын талаарх шүүмжүүд нь технологийн өөрчлөлтийн нөхцөлд дээд боловсролын хамаарал/амьдралаас тасарсан хэрэгцээгүй байдал болон нийгмийн давхраажилт/хөдлөнг чанарын Прокрустын динамикийг авч үзэх ёстой. Коллинз шүүмжлэлт социологигор технологи, боловсрол хоёрын хоорондын харилцааг шийдвэрлэхийг зорьж, ерөнхийдөө технологид суурилсан ажил, боловсролын тогтолцоо, капитализмын ирээдүй гурав хэрхэн өөр хоорондоо харилцан хамааралтай байгааг ойлгохыг хичээдэг. Тэрээр шууд л тэгш бус байдлын тулгамдсан асуудлуудыг шийдэх гэж зүтгээгүй, харин эхлээд боловсролын жуухизмын асуудлыг төвд нь байрлуулснаар дээд боловсролын тулгамдсан асуудлын үндэс болсон бүтцийн динамикийг хөнддөг.

Янгийн өөрийн гэсэн өнгө аястай элэглэлд Коллинз ёж анализ хийжээ. Янгийн үед түүний нэрлэсэн "меритократ тогтолцоо" дээд боловсролын нийтийг хамралтын үр нөлөөг бүрэн мэдрээгүй, мөн шинэ жуухизм хараахан гарч ирээгүй байв. Янгийн шүүмжлэл өөрөө меритократ тогтолцоонд төвлөрч байсан бол Коллинз жуухчлалд анхаарлаа хандуулсан. Аль аль нь гарааны тэгш боломжийг зарчмын хувьд эсэргүүцээгүй боловч үр дагаврын тэгш бус байдлыг бодит байдлын хувьд асуудалтай гэдгийг олж харсан. Тэд хоёулаа бизнес-баримжаатай статус бүлгүүд нэмэгдэж байгааг онцолсон. Янгийн хамгийн хурц шүүмжлэл нь аль хэдийн давуу эрхтэй болсон цөөнхөд олгосон зөвшөөрлийн тамга болох меритократ идеологитой холбоотой байв. Коллинз боловсролын тэлэх түрэмгийлэл нь дунд ангийг өргөжүүлж, олонх болон цөөнхийн давхаргыг ялгахад улам хэцүү болгоно гэсэн. Энэхүү "шинэ анги" соёлын капиталын төлөөх илүү олон янзын маргаан, нийгмийн гэмцлийг үзүүлэх болно. Майкл Янгийн хувьд 1950-аад оноос 2000-аад он хүртэл меритократ тогтолцооны өсөлтөөс үүдэлтэй хамгийн гол асуудал бол тасарсан эрх мэдлийн мэдрэмжийн өсөлт²⁸ байв. Үүнийг өнөөдөр Бранко Миланович "нийгмийн салан тусгаарлах үзэл"²⁹ гэж нэрлээд байгаа (Milanovic, 2016):

"Бизнесийн меритократ тогтолцоо моодонд орсон. Хэрэв меритократчууд тэднийг урамшуулж байгаа нь бас тэдний албан тушаал дэвших нь зөвхөн өөрсдийнх нь мундаг-аас үүддэг гэж итгэдэг бол тэд гавьяагаа хүртэх эрхтэй л гэж мэдрэх болно"... "Тэд өөрсдийнхөө мундагтаа биш, харин үр шим хүртэгчийн хүү эсхүл охин болохоор, аль эсхүл хамаатан садан, танил тал нь үр шим хүртэгчид байсан учраас өндөр албан тушаалд хүрсэн гэдгээ мэддэг хүмүүсээс хавьгүй илүүгээр тэвчихийн аргагүй бардам байдаг" (Young, 2001)

Дээд боловсролын Прокрустын динамик нь нийгэмд боловсролын инфляци, жуухын хэт үйлдвэрлэл болон боловсрол юм уу ажлаар дарлуулсан итгэл муутай, ур чадвар тааруу, бүтээлч

²⁸ Орч. А.Х: Би л мундаг учраас өдий дайтай явна гэх албан тушаал дахь бусдаас тасарсан мэдрэмж.

²⁹ Social separatism

байдал багатай ирээдүйн "доод зам" эсхүл өндөр бүтээлч байдал, эрх мэдлийн илүү тэгш хуваарилалт, хувь хүний бие даасан байдал, харилцан хамаарлаар тодорхойлогддог уян хатан үйлдвэрлэл бүхий "пост-Фордист"-ын "дээд зам"-ын аль нэгийг сонгох сонголттой тулгардаг. Шинэ сургалт нь тогтолцооны чиг үүрэгтэй байж болох ч орчин үеийн сурган хүмүүжүүлэгчид үйлдвэрлэлийн шинэ материаллаг нөхцөл хэмээн зүйрлэн үздэг Цахиурын хөндийн төрлийн салбарын цөөнх элитэд зориулсан болов уу.

4. Социологийн онол ба нийгмийн хувирган өөрчлөлт

Технологийн орлолт нь Коллинзийн анализыг капитализмын бүтцийн кризисийг авч үзэх, цаашлаад "далдлагдсан Кейнсизм"-ийг төрийн практикт ашиглахад хүргэсэн. Технологийн орлолт нь ажилгүйдэл, ажлын байрны өрсөлдөөний бодит байдлыг нуун далдлах боломжгүй болов уу, яагаад гэвэл энэ нь дижитал Утопи хэмээх "Калифорнийн идеологи"-д тусгагдсан утопи хувилбараас хол байгаа, гэсэн ч гэлээ хүн бүр баян чинээлэг мөртлөө цаанаа уйтгар гунигтай байх болно (Barbrook & Cameron, 1996, p. 44).

Улсын төсвийн хямрал, нийгмийн хөдөлгөөний дайчилгаа, нийгмийн хувьсгал хэрхэн гарахыг Коллинз яг таг мэдэхгүй ч гарах нь магад гэж үздэг. Капитализмын дараах ирээдүй рүү шилжих, өөрөөр хэлбэл, "капитализм хангалттай муудах үед" социализм руу шилжинэ гэлтэй (Collins, 2013, p. 58; 66). Ажилчин ангийн гар хөдөлмөр роботуудаар орлогдох ирээдүй ирж, боловсрол өөрөө далдлагдсан Кейнсизмийн үйл ажиллагаа явуулах цорын ганц хөшүүрэг хэвээр үлдэнэ. Гэсэн хэдий ч Коллинз *Жуухын нийгэм* (Marglin & Schor, 1992) номоо хэвлэх үед Кейнсийн төрийн оролцоотой капитализмын Алтан үе аль хэдийн дуусчихсан байсан. Дээд боловсролын шинэ улс төрийн эдийн засаг болох Кейнсизмийн хэтийн төлөвийн бууралт дээр хавсраад цалингийн бууралт нь Америк мөрөөдлийг орхих, ихэнх ядуу болон дунд орлоготой гэр бүлд зохицуулах боломжгүйгээр өсөн нэмэгдэж буй зардлын дарамтыг учруулж байна. Гэр бүлийн 75 хувь нь жилийн орлогынхоо 20-оос доошгүй хувийг дээд боловсролд зориулж төлдөг (янз бүрийн оюутны тэтгэлгийг тооцож хасаад хасаад) (Goldrick-Rab, 2016, p. 4).

Коллинзийн зөрчилдөөний социологи нь норматив үүрэг даалгавар, үндэслэл байхгүй гэж шүүмжлүүлж чамлагддаг. Зөрчилдөөний онолын байр суурь, үзэл баримтлал нь өөрийн гэсэн хязгаартай:

Эдгээр төстэй байр суурь нь соёл болон идеологиос чимээлэхээс гадна бас тайлбарлах хандлагын үнэт зүйлээр үнэмшилтэй болох боломжтой гэдгийг тэр мэдээгүй бололтой. Тухайлбал, тэрээр либерал утилитаруудын идеологи болон түүний хувийн ашиг сонирхол, нөөц, өрсөлдөөн, нийгмийн сүлжээ, эвсэл холбоо, бэлгэ тэмдэг нь яаж хэрэгсэл болдог гэх мэт ёс суртахууны үнэт зүйлсийн талаар бараг юу ч хэлээгүй (Seidman, 2017, p. 91).

Коллинзийн зөрчилдөөний онол нь өмнө нь голлож байсан Талкотт Парсонсын бүтцийн функционализмаас салахыг оролдсон. *Жуухын нийгэм* нь боловсролын шүүмжлэлт социологийн өөр нэгэн сонгодог бүтээл болох Боулз, Гинтис хоёрын *Капиталист Америк дахь сургуулилалт*-тай (Bowles & Gintis, 1976) бараг зэрэг төрсөн. Удаах ном нь боловсролын илэрхий талуудыг үл хайхарч, системийн хамгийн чухал талуудыг редукционист буюу нийлмэл ярвигтай үзэгдэл болохынх нь хувьд энгийн бүрэлдэхүүнээр нь задалж³⁰ "шинжлэх ухаанч"-аар тайлбарласныг хэтрүүлэн үнэлж, "гялалзсан функционалист" бүтээл гэж тодорхойлогджээ (Cohen & Rosenberg, 1977, p. 116).

Харин нөгөө номын хувьд (Collins, 1998), Коллинз социологийг философиос нь салгалгүйгээр "социологийн бодлын хэлбэрт гүн гүнзгий нэвтрэх зам" болгон илүү өргөн хүрээтэй бүтээл туурвижээ. Эсрэгээрээ, Гинтисийн сүүлд хийсэн синтез (Gintis, 2017) нийгмийн шинжлэх ухааныг орвонгоор нь шинэчлэхийг шаарддаг. Гинтис салаалж ажиллах, шинэ хувилбар гаргаж ирэхээс

³⁰ Reductionist

илүүтэй салбар дамнасан байдал³¹ болох нийлмэл ярвигтай асуудлыг энгийн бүрэлдэхүүнээр нь задалж, салбар салбараас хамтран нийлж нэг цэг рүү чиглэж ажиллах шинжлэх ухааны хандлагыг³² дэмждэг (Khuu, et al., 2019). Бүх нийгмийн шинжлэх ухааны сонгогдсон арга зүй болох рационал сонголтын загварчлал болон “бие хүний байдал” (“хүний биологийн зүйлүүдийн гол онцлог”) дээр суурилсан “нэг чигт империализм”-ийг Гинтис ил тод дэмждэг (Gintis, 2017, p. xiv). Бие хүний зан хандлын загварчлал нь эдийн засгийн илүүд үзсэн сонголт, дэг журам, хязгаарлалтыг улс төрийн ардчилалтай үндсэндээ авцалддаг гэж үздэг. Өөрөөр хэлбэл, “зах зээл нь хүмүүсийн хувийн амьдралд олгодогтой ижил эрх мэдлийг нийгмийн амьдралд олгодог ба энэ хослол нь нийгмийн илүүд үздэг тэр л үр дүнг хэрэгжүүлэх эрх мэдлийг илэрхийлдэг” (Gintis, 2017, p. 1).

Гинтисийн социобиологийн идеализм нь соёлыг хүн амын “амжилтад” чиглэсэн, цагийн хугацааны явцад яаж дасан зохицох чадвартай гэж үздэг. Соёл нь олон төрөлт байдал, тэгш бус байдал, ноёрхол, хүчирхийллээр дүүрэн байдаг нь яах аргагүй асуудал мөн - нэг соёлын таатай орчин, үржил нь ихэвчлэн нөгөөгөө дарлах, тэр ч бүү хэл устгах дээр тогтдог. Ген-соёлын зэрэгцэн хувьсал гэх онолыг ноёрхлын хэд хэдэн боломжит хэлбэрийг хууль ёсны болгоход ашиглаж болно. Гинтис нийгмийн шинжлэх ухааныг бүхэлд нь эдийн засгийн империализмыг эсэргүүцэхэд гар бие оролцохыг уриалж байгаа боловч үүнийг тэмдэглэх нь Нөгөөгөө ноёрхож, өмчийг нь булаасан нэг соёлын империализмд хамсаатан байсныг тэмдэглэж буй хэрэг.

Коллинзийн орооцолдоо нь нэг шугаман хувьслын замыг төсөөлөх ч үгүй, тийш зүглэх ч үгүй. Нийгмийн бодит байдал нь “бие даасан” биш бөгөөд зөвхөн нийлмэл ярвигтай үзэгдэл болохынх нь хувьд энгийн бүрэлдэхүүнээр нь задалж, мөн амьдралын бодит байдлыг ойлгохоор нягт ажиглах, бодох замаар ойлгож авч болно. Түүний зөрчилдөөний социологи эмпирик ажиглалтыг ерөнхий байдлын өндөр түвшинд холбодог боловч түүний асуугаагүй асуулт бол зөрчилдөөний социологи ямар хувирган өөрчлөлтийн дунд байдаг вэ? Социологийн ажиглалтууд үргэлж “юмсын дунд” байдаг – “*in medias res*”:

Бодож буй хувь хүн ... хувийн амьдрал дахь түүний дотоод яриа нь томоохон ярианы нэг хэсэг болж, асуудлуудад хувь нэмэр оруулдаг учраас л сүлжээнд чухал ач холбогдолтой зүйлийг боддог... Үнэн гэдэг нийгмийн сүлжээнд бий болдог, өөрөөр хэлбэл, энэ нь өөр хаана ч үүсэх боломжгүй (SoP, 8777).

Социологийн рефлексив чанар нь “үнэний ариун дагшин объект”-т халдаж, тэр ч бүү хэл айхгүйгээр олны өмнө шүүмжилдэг гэдгийг Коллинз хүлээн зөвшөөрдөг. Марксын нэгэн адил Коллинз философичдод социологийн рефлексив чанар бага зэрэг дутагдаж, рефлексив чанараа абстракц буюу хийсвэрлэл рүү улам бүр гүнзгийрүүлж булшлах хандлагатай байдаг гэж үздэг: философичдын “*бэрхшээлийн гүнийг олж илрүүлэх нь ... тэднийг эхлээд абстракц тэгээд рефлексив чанар нэмэгдүүлэх дарааллаар хөтөлдөг*” аж (Collins, 1998, p. 878). Философийн “гүн асуудал” нь нийгмийн хувьд “сайн асуудал” байдаггүй. Бодох гэдэг цаг хугацаа ба орон зай дотор оршиж, өрнөж буй хэл, бусад хүмүүс гэх мэт бусад бодит юмстай зэрэгцэн оршдог гэдгийг Коллинзийн реалист *социологийн когито* баталдаг. Социологийн реализм нь бодох гэдгийг хэрэв өөрчлөлтийн замнал нь (тэгш бус байдал, зах зээлжилт гэхчлэн) хор хөнөөлтэй, шударга бус байвал социологичдын хувьд бид юу хийх ёстойг эргэцүүлэн бодоход туслах бэлэнчлээд өгсөн цөөн хэдэн арга хэрэгсэл болж өгдөг гэж үздэг.

³¹ Transdisciplinarity

³² Convergent scientism

5. Дүгнэлт – зөрчилдөөний социологи дахь байхгүйн социологи³³

Коллинзийн жуухизмын шүүмжлэлд бидний өгч чадах гол шүүмж бол түүний зөрчилдөөний социологи нь илүү ерөнхий гэхээс аналитик эсхүл тайлбарламж дутмаг гэдэгт биш. Энэ нь түүний дэндүү олон зүйлийг шалгаагүй, хөндөөгүй үлдээдэг "явцуу рефлексив чанар"-ын арга барилтай холбоотой (Fuller, 1999). Шинжлэх ухааны реализмын илүү итгэмтгий хэлбэрүүд нь мэдлэгийн социологичдын шаардсан рефлексив чанартай мөргөлддөг гэдгийг Коллинз хүлээн зөвшөөрдөг. Коллинзийн амбицлаг зөрчилдөөний социологи нь илүү өргөн рефлексив чанарын боломжит байдлыг хэр зэрэг агуулж, Коллинз салгахаар зорьсон Парсонч бүтцийн-функционализмын жинхэнэ шүүмжлэлийг (Barber, 1956) хэр зэрэг хөндсөн бэ?

Зөрчилдөөний социологи нь динамик өөрчлөлт, системийн хөгжлийг мөрдөх замаар бүтцийн-функционализмын статик тайлбар руу чиглэсэн хандлагыг хэсэгчлэн туулдаг. Харин нийгмийг өөрчлөх бодлогын түүхэн тайлбар нь шинэ төлөв хуучин төлөвөөсөө ямар бодитой ялгаатай эсхүл ёс суртахууны хувьд "илүү дээр" эсхүл "илүү дор" болох нь тодорхойгүй байх хандлагатай байдаг. Нийгмийн өөрчлөлтийн онол нь байнгын хөдөлгөөнийг дүрслэхээс илүүг хийж чадах уу, өөрөөр хэлбэл энэ нь *хувирсан өөрчлөлтийг* гийгүүлж чадах уу? Коллинз бэлгэ тэмдгийн болон соёлын капиталыг хуримтлуулах замаар нийгмийн хүчийг монополичлох, хаах оролдлогуудыг ихээхэн шүүмжилдэг. Гэсэн хэдий ч боловсролын жуухизм ба нийгмийн зөрчилдөөний онол нь боловсрол ба мерит гэх мэт янз бүрийн ойлголтуудын хоорондох харилцааны зүй ёсны анализаас гадна мерит ба ажил эрхлэлт, оюуны бүтээлч байдал ба зогсонги байдал гэх мэт боловсролын болон нийгмийн талаарх бодитой тайлбарыг өгч чаддаггүй. Суралцахуйн жинхэнэ үнэ цэн эсхүл философийн гүнзгийрлийн талаарх консерватив ойлголтыг илчилсэн боловч зөрчилдөөний онол нь өрсөлдөөн, хувийн ашиг сонирхол, утилитарианизм зэргийн давамгайлсан, үндсэндээ консерватив идеологийн цогцолборыг бодитоор эсэргүүцэх чадваргүй мэт. Энэ нь нийгмийн давхраажилт хэрхэн үүсдэгийг хэлж өгдөг боловч үүнийг хэрхэн өөрчлөх эсхүл өөрчилж болох талаар дуугардаггүй.

Жуухын нийгэм 1979 онд анх хэвлэгдэх үед Шинэ Барууныхан боловсролыг сургалт, шалгарлын ерөнхий тогтолцоо гэж хүлээн зөвшөөрсөн байсан ойлголтыг бөөний бараа болгох үлэмж өөрчлөлтөөр сольж амжаагүй байв. Хожим нь индивидуализм, энтрепренёрализм руу иж бүрэн шилжиж, иргэн бүрийг өөрийнхөө боловсролд гол хөрөнгө оруулагч болгохын сацуу тэгш бус байдал, мөлжлөгийг асар ихээр нэмэгдүүлж байна. Бюрократ эрх мэдэл мөн нэмэгдсэн боловч төр-зах зээл хоёрын холимог шинэ эрх мэдлийг бий болгон түшиглэх болов. Боловсролыг төрөөс салгах номлол нь хувь хүний сонголт, үр ашиг, бүтээмж, ерөнхийдөө эдийн засагт өгөөжийг амладаг боловч тэр дундаа шалгарсан хувийн хэвшлийнхэнд илүү их өгөөжийг амладаг. Эдгээр зөрчилдөөнтэй нийгмийн хүчин зүйлс нь боловсролын, эдийн засгийн бас нийгмийн тэгш бус байдлыг зөвтгөж, босоо болон хэвтээ аль аль тэнхлэгийн нийгмийн алсрал хөндийрлийг нэмэгдүүлж байна.

Ирис Марион Янг нь хувь хүмүүс бол нийгмийг ёс суртахуунтай холбогч-оролцогч болохын хувьд хүмүүсийн үүрэг хариуцлагад суурилсан нийгмийн харилцааны өөр загварыг санал болгож, тэдний хүчийг дэлхийн шударга бус бүтцийн үйл явцтай холбон тайлбарладаг (Young, 2006).

³³ Орч. А.Х.: Sociology of absences буюу байхгүйн социологи нь байдаг ч түүнийг байдаггүй мэтээр үл хайхарч, үүнийг энгийн мэтээр дассан байдлыг шүүмжилж байгаа зүйлийг байгаагаар нь гаргаж ирэхийг зорьдог социологич Боавентура де Соуса Сантосын хөгжүүлсэн социологийн онол. Энэ онол нь колоничлол, капитализм, хежемони буюу жанжлалийн хүрээнд сэдвээ тогтоодог. Тухайлбал, мэдлэгийн моносоёл буюу мэдлэг гэдэг бол зөвхөн л шинжлэх ухааны мэдлэг гэж хар ухааны мэдлэгийг үгүйсгэдгийг, аль эсхүл шинжлэх ухааны мэдлэг гэхээрээ л өрнийн мэдлэгийн жанжлалыг авч үзэж, дорнын мэдлэгийн санг үгүйсгэх маягтай байдгийг байхгүйн социологи шүүмжилдэг. Олонхын дарангуйллаар цөөнхийн дуу хоолойг байхгүй болгохоос авахуулаад зах зээл хөгжиж, эдийн засаг өсөх нэрийдлээр байгаль сүйдэж байгааг, мөлжлөг, тэгш бус байдал нэмэгдэж байгааг байхгүй болгож харагдуулах хүртэл байхгүйдэл нь хаа сайгүй байдаг.

Тэрээр үйлдвэрлэл, түгээлт, маркетингийн үйл явц нь (тэрээр өгүүлэлдээ хувцасаар хангах тухайд авч үзсэн, харин энэ өгүүлэлд бид дээд боловсрол, жуухчлал дээр авч үзэж болно) шударга ёсны төлөөх ёс зүйн үүрэг хариуцлагад хэрхэн холбогддог тухай жишээлдэг. Хариуцлагыг нийгэмтэй холбох загвар нь шударга бус байдлыг бий болгох бүтцийн үйл явцад өөрсдийн үйлдлээрээ хувь нэмрээ оруулж буй бүх нийгмийн оролцогчид тэдгээр шударга бус нөхцөл байдлыг арилгахын тулд ажиллах үүрэгтэй гэж хэлдэг.

"Байхгүйн социологи" гэдэг нь Боавентура де Соуса Сантосын гаргаж ирсэн нэр томъёо бөгөөд чимээгүй-дуугүй байлгах байдлыг тодорхой түүхэн үйл явцаар идэвхтэй үүсгэсэн байхгүйдлын үе гэж ойлгоно. Социологи бүр, боловсролын түүх бүр "эхний ээлжинд гадуурхагдах, дарагдах эсхүл эхист буюу байхыг нь зөвшөөрөхгүй байгаа" (Santos, 2001, p. 191) зарим нэг туршлагыг өөртөө агуулж байдаг. Дээд боловсрол, жуухчлалын нь шударга ёсыг тогтоох хариуцлага хүлээдгийн хувьд, материаллаг болон соёлын ноёрхол, шударга бус байдлын асуудлыг хөнддөг салбар болох байхгүйн социологид анхаарал хандуулахыг социологичдод үүрэг болгодог. Дээд боловсролын маргаанд эпистемийн эрх чөлөө, эпистемийн ноёрхол, эпистемийн шударга бус байдлын³⁴ талаарх асуудлууд гарч ирсэн бөгөөд социологид гол урсгал болгон авч үзэхээс өөр аргагүй болсон. Империалист-колониист, рацист-сексист хүчний тогтоцтой гүн орооцолдсон бүтцийн-функционалистуудын гэнэн реализмыг ашиглан сургасан социологидыг дэлхийн дийлэнх нь хүлээн зөвшөөрөхөө больсон. "Арван зургадугаар зууны урт хугацааны" "эпистемид буюу мэдлэгийн системийн үстгал" нь нийгмийн шинжлэх ухаан үүсэх нөхцөлийг бүрдүүлсэн (Grosfoguel, 2013). Энэхүү нийгмийн шинжлэх ухааны колонийн орчин үеийг колониос суллахаар нийгмийн "бодит байдал"-ыг тодорхойлох, танин мэдэх ондоо, эпистемийн дуулгаваргүй аргуудыг эрэлхийлдэг судлаачид идэвхтэй тэмцэж байна (Mignolo, 2001).

Хөдөлмөрийн зах зээлд боловсон хүчин нийлүүлэх үүрэгтэйгээс гадна неолиберал боловсролын шинэчлэлийн хамгийн чухал бөгөөд анзааралгүй өнгөрч чадашгүй тал нь боловсролгүйжилт буюу боловсролгүй болгох явдал. Боловсролыг хөдөлмөрийн зах зээлийн төлөөх функциональ талаас нь л байнга ярьдаг, гэтэл хэзээ ч "боловсрол" гэж яг юу болох талаар бараг ярьдаггүй (Rømer 2011). Энэ нь өндөр мэдлэгийн эрэлт хэрэгцээг бий болгож буй мэдлэгийн өндөр стандарт, тодорхой философийн идея эсхүл техник-шинжлэх ухааны дэвшилд хүрэх асуудал биш, харин боловсролын салбарын бизнес эрхлэгчдийн хоорондын өрсөлдөөн нь жолоодлогоо алдсан дээд боловсролын тэлэлт, үүний Прокрустын дилеммад хөтөлж байна.

Коллинзийн жуухизмын талаарх зөрчилдөөний шүүмжлэл нь амбицаар дутагдаагүй. Энд хэлэлцсэн бүтээлүүд нь Веберийн, Марксын болон Парсоны онолын дэвсгэр дээр үндэслэсэн, гэхдээ абстракт бус анги, хүйс, арьс өнгөний анализ, мөн философиийн тодорхой агуулгатай ёс суртахууны болон хүмүүжлийн алсын хараагаар тодорхойлогддог улс төрийн эдийн засаг тал дээр мэдэгдэхүйц дутагдалтай. Эдгээр дутагдал нь зөрчилдөөний социологийн эх болох бүтцийн функционализмаас гаралтай. Хэрэв боловсролын зорилго нь функционалистуудын үздэгчлэн капиталист бүтээмж, ашгийг нэмэгдүүлэх гэсэн хүмүүн капиталын хөрөнгө оруулалт биш юм бол энэ дэлхий дээр ямар аймшигт, дөнгөн данган ач холбогдолтой, дэндүү амархан хэрэглээнээс гарах болсон, гэхдээ бас нөөцийн хомсдолд өртөж, хямрал үүсгэдэг тогтолцоо болох бидний нэрлэж заншсан "боловсрол" нь юуны төлөө вэ?

Социологи заах болгонд танин мэдэхүйн, шүүмжлэлт, норматив апориа буюу мэдээжийн гэсэн болгон мэдээжийн биш гэж эргэлзэх боломж нээгддэг. Оюутнууд хэм хэмжээ, нийгмийн хүчин зүйлсийг ойлгохын тулд социологиор бодох нь тэд эрх мэдэл, нөөцийн ялгаа, хүний эмзэг байдлын талаарх асуултуудыг авч үзнэ гэсэн үг. Социологийн боловсролын зорилго нь хувь хүн бүр боловсролын үйл ажиллагаа, үйл явц, хэм хэмжээ, институциудыг хөнгөвчлөх эсхүл хүндрүүлэх

³⁴ Орч. А.Х: Эпистем гэж мэдлэгтэй холбоотой ойлголт. Эпистемийн шударга бус байдал буюу мэдлэгтэй холбоотой шударга бус явдалд жишээлбэл гадуурхах, дуугүй болгох; хүний утга санаа, оруулсан хувь нэмрийг системтэйгээр гуйвуулах, буруу тайлбарлах; хүний байр суурийг дутуу үнэлэх, мохоох; эрх мэдэлд шударга бус ялгаа гаргах; үндэслэлгүйгээр үл итгэх зэрэг багтана.

технократ тогтолцоогоор удирдуулсан ертөнцөд нийгмийн хөдлөнг чанарын албадлага, амлалтад баригдсан ч гэсэн оюутнуудыг гайхах, бие даан бодоход оршино. Коллинзийн жуухизмыг мэдээжийн биш хэмээн эргэлзсэн онолшилгоо нь дээд боловсрол тасралтгүй хавтгайрч байгаа тул онцлог шинжээ алдаагүй байна. Түүгээр ч барахгүй зөрчилдөөний социологийн үндсэн байр суурь, гол үндэс нь либерал өрсөлдөөн, дор хаяж өнөөгийн тогтолцоо нуран унах хүртэл хэвээр байна. Боловсролын системүүд неолиберализмын бүх нийтийг хамарсан, түгээмэлжүүлэх байр суурь болох өрсөлдөөнт индивидуализмын логикийг зөвтгөхийн тулд тасралтгүй дарамт шахалтанд орж ирсэн (Davies, 2017). Дээд боловсролын тогтолцоог байнга өргөжүүлэн тэлж байгаа нь хувь хүн болон бүлгийн нийгмийн хөдлөнг чанарын амласан хувилбарт хүргэхгүй байна. Үүний оронд ийм тэлэлт нь жуухын инфляци, давуу эрхийн хуримтлал, нийгмийн хашаас, нийгмийн салан тусгаарлах үзлийн чиг хандлагад тасралтгүй хүргэдэг.

Хэрэв нийгмийн бүх тулгамдсан асуудал зөрчилдөөнт шинжтэй бөгөөд захирах, захирагдах харилцаагаар бүтэцлэгдсэн байдаг бол (Seidman, 2017, p. 88) зөрчилдөөний социологийн хамгийн хүчтэй шүүмжлэл нь неолиберал (сонгодог либералтай харьцуулахад) өрсөлдөөнт утилитаризмын төрийн ноёрхогч идеологийг эсэргүүцэх бус харин түүнийг илэрхийлэх явдал билээ. Яг одоо болж буй боловсролын талаарх маргаан 1970-аад оны үед гарч ирж байсан асуудлаас тийм ч их ялгаатай биш гэдгийг *Жуухын нийгэм* бидэнд сануулсан хэвээр. Тэр асуудлууд алга болоогүй, тэр ч бүү хэл огт өөрчлөгдөөгүй байгаа нь гайхшируулам. Сэйдман Коллинзыг нийгэм дэх ёс суртахууны алсын харааны асуудлаас мултарч чадаагүй бөгөөд "түүний бүтээл ёс суртахууны ач холбогдлын хувьд ихээхэн харалган" (Seidman, 2017, p. 91) гэж шүүмжилж, түүнчлэн өргөжүүлэх ба үгүйсгэх зөрчил бүхий динамик хандлагадаа хүлэгдэж, бүтэцлэгдсэн нийгмийн давхраажлын онолыг боловсруулсан гэжээ. Бүрэн дүүрэн бюрократжсан, технологийн эдийн засагт хүмүүсийн албан тушаал-байр суурийг тодорхойлох хамгийн чухал хүчин зүйл бол боловсрол хэвээр байна. Заавал сургуульд суралцах, боловсролын жуух гэрчилгээ авах нь жишиг болсон тохиолдолд дээд боловсрол нь боловсролоор тодорхойлогддог нийгмийн хөдлөнг чанарыг амлаж, шинэ жуухизмаар ногдуулсан эдийн засгийн ихээхэн хохирлын хамт бодит байдал дээр хөдлөнг чанарт бодитоор хүрэх хязгаарлагдмал боломжийг бий болгож байна.

Боловсролын тогтолцоо хэдий чинээ их жуух үйлдвэрлэнэ, ажлын байрууд төдий чинээ их жуух шаардах ёстой. Үүнийн өсөлт ба хэн үүнийг даах вэ, "боловсролын зэргийн инфляци" ба боловсролын салбар басалбарынхаа үнэтэй дүйцэхүйц илүү өндөр цалин бас статустай "илүү дээр" ажлын байр амласан тэр өгөөжөө өгч чадахгүй байгаа зэрэг бүх асуудлууд хэвээр л. Өндөр цалинтай мэргэжлүүд статусаа хадгалахын тулд хамтрах тэмцэхээр хичээх ёстой байтал дунд шатны ажил мэргэжил бүхэлдээ алга болж байна. "Доод" боловсролын жуухууд нь бүх нийтээр олж авах боломжтой боловч үнэгүйдэх болж, үнийн өсөлт үргэжилсээр байгаа нь ядуу хүмүүст хамгийн тод тусдаг. Ажлын байрыг автоматжилт эзлэх болсон гэхчлэн технологиос болж "сайн" ажлын байр хомсоддог. Меритократ тогтолцоог шүүмжилсэн анхны шүүмжлэл нь (Young, 1958) сэрэмжлүүлэг болох зорилготой элэглэл байв. Гэтэл меритократ тогтолцоо нь элэглэл ч биш, сэрэмжлүүлэг ч биш, харин тэгш бус байдлын жинхэнэ үндэслэгч гэдэг нь улам тодорхой болсоор байна. Янгийн 1958 онд төсөөлж байсан эцсийн эсэргүүцэл 2033 он гэхэд болох нь магадлал багатай, харин ангийн зөрчилдөөн улам бүр газар авах магадлал өндөр бололтой. Гэхдээ энэ нь төсөөлж байснаас бага хувьсгалт шинжтэй байх болов уу (Collins, 1979, p. 71)? Өсөн нэмэгдэж буй тэгш бус байдал, арьс өнгөөр гадуурхах, хүйсээр ялгах, колоничлол зэргийн бүхий л зөрчилдөөн нь кризис буюу хямралын хандлагыг нэмэгдүүлж, тогтворжилтын хүчин зүйлсийг хэзээ нэгэн цагт түлхэн унагаж магад.

Bibliography

- Barber, B., 1956. Structural-functional analysis. *American Sociological Review*, 21(2), pp. 129-135.
Barbrook, R. & Cameron, A., 1996. The Californian ideology. *Science as Culture*, 6(1), pp. 44-72.
Bateson, G., 1958. *Naven*. 2nd ed. s.l.:s.n.
Becker, G. S., 1964. *Human Capital*. Chicago, IL: University of Chicago Press.

- Berlant, L., 2011. Cruel Optimism. Durham: NC: Duke University Press.
- Bhambra, G., 2014. Connected Sociologies. London: Bloomsbury.
- Bowles, S. & Gintis, H., 1976. Schooling in Capitalist America; Educational Reform and the Contradictions of Economic Life. London: Routledge and Kegan Paul.
- Brown, P. & Lauder, H., 1991. Education, Economy and Social Change. International Studies of Sociology of Education , pp. 3-23.
- Cohen, D. K. & Rosenberg, B. H., 1977. Functions and Fantasies: Understanding Schools in Capitalist America. History of Education Quarterly, 17(2), pp. 113-137.
- Collins, R., 1975. Conflict Sociology: Toward and Explanatory Science. New York: Academic Press.
- Collins, R., 1979. The Credential Society: An Historical Sociology of Education and Stratification. New York: The Academic Press.
- Collins, R., 1998. The Sociology of Philosophies: A Global Theory of Intellectual Change. Cambridge, MA: Harvard University Press.
- Collins, R., 2013. The end of middle-class work - no more escapes. In: Wal, et al. eds. Does Capitalism Have a Future?. Oxford: Oxford University Press, pp. 37-70.
- Connell, R., 2019. The Good University: What Universities Actually Do and Why It's Time for Radical Change. London: Zed Books.
- Cottom, T. M. C., 2017. Lower Ed: The Troubling Rise of For-Profit Colleges in the New Economy. New York: The New Press.
- Darling-Hammond, L., 2015. New Learning for A Rapidly-Changing World. [Online]
Available at: <https://www.youtube.com/watch?v=f14g0OG4mz0>
- Davies, W., 2017. The Limits of Neoliberalism. London: Sage.
- Doxtdator, B., 2017. A Field guide to jobs that don't exist yet, s.l.: s.n.
- Fuller, S., 1999. Review: One Small Step for Philosophy, One Giant Leap for the Sociology of Knowledge. Contemporary Sociology, 28(3), pp. 277-280.
- Gintis, H., 2017. Individuality and Entanglement: The Moral and Material Bases of Social Life. Princeton: Princeton University Press.
- Goldrick-Rab, S., 2016. Paying the Price: College Costs, Financial Aid and the Betwrayl of the American Dream. Chicago: University of Chicago Press.
- Graeber, D., 2013. On the Phenomenon of Bullshit Jobs: A Work Rant by David Graeber. [Online]
Available at: <https://strikemag.org/bullshit-jobs>
- Graeber, D., 2018. Bullshit Jobs A Theory. New York: Simon and Schuster.
- Grosfoguel, R., 2013. The Structure of Knowledge in Westernized Universities: Epistemic Racism/Sexism and the Four Genocides/Epistemicides of the Long 16th Century. Human Architecture: Journal of the Sociology of Self-Knowledge, 11(1).
- Headsworth, S. & Freese, J., 2016. Credential privilege or Cumulative Advantage? prestige, productivity and placement in the academic sociology job market. Oxford: Oxford University Press.
- Iriye, A., 2013. Global and Transnational History: The Past, Present and Future. Houndmills, Basingstoke: Palgrave.
- Lemann, N., 1999. The Big Test: The Secret History of the American Meritocracy. New York: Farrar, Strauss & Giroux.
- Marglin, S. & Schor, J., 1992. The Golden Age of Capitalism: Reinterpreting to postwar experience. Oxford: Clarendon Press.
- Mignolo, W., 2001. Delinking: The rhetoric of modernity, the logic of coloniality and the grammar of de-coloniality. Cultural Studies, 21(2-3), pp. 449-514.
- Milanovic, B., 2016. Globalisation, Migration and the Future of the Middle Classes. s.l., s.n.
- OECD, 2010. The Case for 21st Century Learning. Paris: OECD.
- Santos, B. d. S., 2001. Nuestra America: Reinventing a Subaltern Paradigm of Subaltern Recognition and Redistribution. Theory, Culture and Society, pp. 185-217

ДЭЛХИЙН ДЭГ ЖУРМЫГ ӨӨРЧЛӨГЧ ДАЙН БА МОНГОЛ УЛС

Б.Эрдэнэбат

ШУТИС, Механик Тээврийн Сургууль,

Тээврийн салбарын нисэхийн профессор Доктор (Ph.D, профессор

Д.Түмэнжаргал

МУИС- УТС, ОУХНУС-ийн Улс төр

судлалын тэнхимийн ахлах багш, Доктор (Ph.D)